

БАТЛАВ
БОЛОВСРОЛЫН БОДЛОГО БАГШИЙН ХӨГЖЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

2023 оны 1 дүгээр сарын 11 өдөр

МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛЭЭР 2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЯВАГДАХ
МОНГОЛЫН МАТЕМАТИКИЙН 59-Р ОЛИМПИАДЫН II ДАВАА,
ДҮҮРГИЙН ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЗОРИЛГО: Сурагчдын сэтгэн бодох чадвар, сэтгэлгээний хурдыг нэмэгдүүлэх, ой тогтоолт, оюуны чадамжийг сайжруулах, нийслэл болон улсын математикийн олимпиадад оролцох багш, сурагчдыг сонгон шалгаруулахад оршино.

НЭГ. ОЛИМПИАДЫН АНГИЛАЛ:

1. Олимпиадыг 5-6, 7-8, 9-10, 11-12, бага ангийн багш, дунд ангийн багш гэсэн 6 ангиллаар 2023 оны 2 дугаар сарын 11, 12-ний өдрүүдэд зохион байгуулна.
2. 5-6, 7-8 ангийн ангилал нэг өдөр 4 бодлого, бусад ангилал хоёр өдөр тус бүр 3 бодлого бодно.

ХОЁР. ДҮҮРГИЙН ОЛИМПИАДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Дүүргийн олимпиадыг төрийн болон төрийн бус өмчийн сургуулиас шалгарсан 5-6, 7-8, 9-10, 11-12 ангийн сурагчид болон бага ангийн багш, дунд ангийн багш нарын дунд зохион байгуулна.
2. Сурагчид I даваанд оролцсон ангилалдаа оролцоно. <http://www.mmo.mn/post/?id=257> нийтлэгдсэн дүүргүүдийн дүнгийн жагсаалтыг олимпиадын бүртгэлд ашиглана.
3. Олимпиадын I даваанд (12-р сарын 9-нд зохион байгуулагдсан) оролцож 1 буюу түүнээс дээш оноо авсан, дүүргийн (Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийг нэг дүүрэг гэж тооцно) жагсаалтын эхний 50 байрт шалгарсан сурагч сургууль харгалзахгүйгээр дүүргийн олимпиадад оролцоно. Оноо тэнцсэн тохиолдолд 50-тай хамгийн ойр байхаар оноог тасална. Хэрвээ 50-тай хамгийн ойр хоёр байр гарвал сурагчдад ашигтай байхаар тасална. Жишээ нь 40-60 байрын сурагчид ижил оноо авсан тохиолдолд 60 сурагч дүүргийн олимпиадад шалгарна. Харин 41-60 байрын сурагчид ижил оноо авсан тохиолдолд 41 сурагч дүүргийн олимпиадад шалгарна.
4. Дүүргийн олимпиадад төрийн болон төрийн бус өмчийн сургуулиас шалгарсан 5-6, 7-8, 9-10, 11-12 дугаар ангийн ердийн сургалттай сургуулиас олимпиадын I даваанд 1 буюу түүнээс дээш оноо авсан 3 хүртэлх тооны сурагч, гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиас 5 хүртэлх сурагчийг нэмэлтээр оролцуулна. Энэ зохицуулалтыг тухайн сургуулиас эхний 50 байрт дээрх тооны сурагч шалгараагүй тохиолдолд ашиглана. Жишээ нь аль нэг ангилалд нэг сургуулийн 10 сурагч шалгарсан бол нэмэлтээр 5 сурагч оролцуулахгүй. Сурагчдыг I даваанд авсан онооны дагуу шалгаруулна. Сурагчдын оноо тэнцсэн тохиолдолд оноо тэнцсэн сурагчдын дунд дотоод шалгаруулалт зохион байгуулна.

- Сургууль бүрээс бага, дунд ангийн тус бүр 3-5 багш оролцоно. Дүүргийн олимпиадыг Боловсролын хэлтэс нь мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, материал засах багш нарын баг, ахлагчийг томилон ажиллуулна. Материал засах багш нарын баг Монголын Математикийн Олимпиадын Хорооноос ирүүлсэн бодлого засах аргачлалын дагуу сурагчдын материалыг засна.
- Зохион байгуулагчид дүүргийн олимпиадад амжилттай оролцож медаль хүртсэн багш сурагчдын материалыг дижитал хэлбэрээр бэлдэж (google drive, dropbox гэх мэт) нийтэд ил байршуулж веб холбоосыг нь Монголын Математикийн Олимпиадын хороонд ирүүлнэ.
- Дүүргийн Боловсролын хэлтэс, олимпиад зохион байгуулах сургуультай хамтран удирдамж гаргаж, бүртгэлийн ажлыг зохион байгуулна.
- Олимпиадын сэдвийг нийслэлийн математикийн боловсрол, багшийн хөгжил хариуцсан мэргэжилтэнд тухайн өдрийн 9:00-д цахим шуудангаар илгээнэ.
- Бодлогуудыг засах аргачлалыг бодолт дууссаны дараа буюу бодолт хийсэн өдрийн 15:00-д www.mmo.mn цахим хуудаст байршуулна.
- Олимпиадтай холбоотой маргаантай асуудлыг тухайн дүүргийн комисс эцэслэн шийдвэрлэнэ.
- Олимпиад зохион байгуулсан талаарх тайлан, мэдээг гаргаж 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдөр boldbaatar@edub.edu.mn хаягаар ирүүлнэ.
- Дүүргийн олимпиад 2023 оны 02 дугаар сарын 11, 12-ны өдөр 10:00 цагаас доорх сургуулиуд дээр зохион байгуулагдана.

ДҮҮРГИЙН МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Дүүрэг	Зохион байгуулах сургууль
1	Баянзүрх	33 дугаар сургууль
2	Баянгол	40 дүгээр сургууль
3	Чингэлтэй	57 дугаар сургууль
4	Сонгинохайрхан	Хөгжил цогцолбор сургууль
5	Хан-Уул	52 дугаар сургууль
6	Сүхбаатар	1 дүгээр сургууль
7	Налайх, Багануур, Багахангай	Боловсрол цогцолбор сургууль

ХОЁР. ДАРААГИЙН ШАТАНД ОРОЛЦОХ ЭРХ

- Дүүрэг бүрээс 9-10, 11-12, дунд ангийн 2 багш улсын математикийн олимпиадад оролцох эрх авна.
- Дүүргийн олимпиадад 7-8, 9-10, 11-12 ангийн ангилалд эхний 20 байрт шалгарсан сурагчид, бага ангийн 10 багш, дунд ангийн 10 багш Улаанбаатар хотын математикийн олимпиадад оролцоно.